



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2025 оны 06 сарын 03 өдөр

Дугаар А/427

Ховд

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 56 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сумдын Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн салбар зөвлөлийн гишүүд, Аж ахуй нэгж байгууллагын инженер техникийн ажилтан, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй хариуцсан ажилтнуудад үйлдвэрлэлийн осол, хурц хордлогоос урьдчилан сэргийлэх арга хэмжээг үр дүнтэй зохион байгуулах, арга зүйгээр хангах, зөвлөн туслах, чадавхжуулах сургалтыг зохион байгуулах зардалд 2,580,000 төгрөгийн дэмжлэг үзүүлсүгэй.

2. Дээрх зардалд зарцуулах 2,580,000 (хоёр сая таван зуун наян мянга) төгрөгийг Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2025 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээний 5.6-д тусгагдсан Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын төсөл арга хэмжээний зардлаас тооцож гаргахыг Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Г.Батсайхан), Бүс, орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого, төлөвлөлтийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Б.Анхбаяр) нарт зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (М.Баярт)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

М.АМАРСАНАА



8400001 1266

Zah A/427 Ooh

Аймгийн Засаг даргын 2025 оны
06 дугаар сарын 02-ны өдрийн
А/427 дугаар захирамжийн хавсралт



ТӨСВИЙН ЗАДАРГАА

№	Зардлын нэр, төрөл	Тоо ширхэг, хэмжээ	Нэгжийн үнэ	Нийт дүн
1	Сургагч багшийн замын зардал (онгоцны билет)	2 тал	465,000	930,000
2	Сургагч багшийн томилолтын зардал	5 хоног	170,000	850,000
3	ХАБЭА чиглэлээр контент хийх зардал	2	400,000	800,000
Нийт дүн				2,580,000

-оОо-